



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/22

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймагт “Сэтгэл зүйч, сэтгэл засалчдын анхдугаар чуулган” зохион байгуулахад Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт зардлын дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 144000 /Нэг зуун дөчин дөрвөн мянган/ төгрөгийг 2017 оны Засаг даргын нөөц сан, бусад хуваарилагдаагүй зардлын жагсаалтын “Соёл, спорт хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах” зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ